

# STAROBNÍ DŮCHOD V ČESKÉ REPUBLICE NENÍ PRO CIZINCE SAMOZŘEJMOSTÍ



**Өндөр насны тэтгэвэр гэж юу вэ?** Энэ нь тэтгэврийн системийн тэтгэмж ба заасан нөхцөлийг хангасан иргэн бүр тэтгэвэр авах эрхтэй.

## Тэтгэвэр тогтоох нөхцөлүүд нь юу вэ?

- Тэтгэврийн насанд хүрэх — Хуулиар зөвшөөрсөн иргэдийн тэтгэвэр тогтоолгох нас. Насны хязгаар нь төрсөн он сар өдрөөрөө өөр өөр байдаг.
- Шаардлагатай даатгалын хугацаа - Одоогийн байдлаар (2023 оны 4-р сар) стандарт (зарим онцгой тохиолдолын талаар та нийгмийн зөвлөгөөний үеэр олж мэдэх болно) даатгалын шаардагдах хугацааг 35 жил гэж тогтоосон. Энэ хугацаа нь таны ажиллаж байх үедээ нийгмийн даатгал төлж байсан үе юм. Даатгалын нөхөн төлбөр гэж нэрлэгддэг хугацааг мөн хэсэгчлэн тооцдог (жишээлбэл, хүүхэд асрах, хамааралтай хүн асран халамжлах, 2010 оноос өмнө суралцсан). Гадаадын иргэдийн хувьд гэрээтэй эсвэл гэрээгүй гадаад орнуудад даатгуулсан эсэхээ мэдэх шаардлагатай.

**Өндөр насны тэтгэвэр авахын тулд та хоёр нөхцөлийг хангасан байх ёстой!**

## Гэрээт х Гэрээт бус гадаад орнууд:

Гэрээт гадаад орнууд – Чех улстай олон улсын нийгмийн хамгаалалтын гэрээнд гарын үсэг зурсан орнууд. Энэ тохиолдолд өөр улсад төлсөн даатгалын хугацааг мөн харгалзан үзнэ. Гэсэн хэдий ч БНЧУ, зөвхөн Чехэд ажилласан хугацааны тэтгэврийг олгоно, үүнийг хэсэгчилсэн тэтгэвэр гэж нэрлэнэ.

Жишээ нь: Хэрэв та ЕХ эсвэл ЕЭХ-ийн улсад 10 жил, Чех улсад 25 жил даатгал төлсөн бол. Жилүүдийн нийлбэр нь тэтгэвэр тодорхойлоход шаардагдах даатгалын хугацаатай тохирч байна.

Гэрээт бус гадаад орнууд – Чех улстай олон улсын нийгмийн хамгаалалтын гэрээнд гарын үсэг зураагүй орнууд. Энэ тохиолдолд гадаадын иргэд зөвхөн Чех улсад шаардлагатай даатгалын хугацааг хангах ёстой. Гадаад оронд төлсөн даатгалын хугацааг харгалзан үзэхгүй.

- Гэрээт орнуудын жагсаалт: <https://www.cssz.cz/web/cz/prehled-smluv-uzavrenych-cz>

**АНХААР! ГЭРЭЭГҮЙ АЖИЛЛАХ БУЮУ ХАРААР АЖИЛЛАХАД ДААТГАЛ ТӨЛДӨГГҮЙ. ЭНЭ НЬ АЖИЛЛАСАН ЖИЛҮҮДИЙГ ТООЦОХГҮЙ БА ОРЛОГО НЬ ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭНД НӨЛӨӨЛӨХГҮЙ ГЭСЭН ҮГ ЮМ.**

**Би хэзээ тэтгэвэр авах хүсэлт гаргаж болох вэ?** Та тэтгэвэрт гарахаас 4 сарын өмнө хүсэх боломжтой. Мөн тэтгэврээ дээд тал нь 5 жилийн хугацаатай буцаан авах боломжтой.

**Би яаж тэтгэврийн өргөдөл гаргах вэ?** Та өргөдлөө OSSZ - Okresní správa sociálního zabezpečení - Дүүргийн нийгмийн хамгаалалтын захиргаанд өгнө.

Ажлын байрны жагсаалтууд: <https://www.cssz.cz/web/cz/kontakty>

Өргөдлийг тэтгэврийн хэлтсийн ажилтан бөглөнө (маягтыг урьдчилан цахимаар татаж авах боломжгүй). Бид танд ČSSZ-д (Česká správa sociálního zabezpečení - Чехийн нийгмийн хамгаалалтын захиргаа) цахимаар урьдчилж цаг авахыг зөвлөж байна.



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.

# STAROBNÍ DŮCHOD V ČESKÉ REPUBLICE NENÍ PRO CIZINCE SAMOZŘEJMOSTÍ



Танд хэрэгтэй бичиг баримтууд:

- Биеийн байцаалт – иргэний үнэмлэх, паспорт, оршин суух зөвшөөрөл.
- Боловсролын баримтууд (суралцсан хугацаа болон үргэлжилсэн хугацаа нь тодорхой байх ёстой; тусгай дунд мэргэжлийн үнэмлэх, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, их сургуулийн диплом).
- Эрэгтэйчүүд - цэргийн алба хаасныг нотлох баримт (цэргийн батлах).
- Эмэгтэйчүүд - хүүхэд асрах тухай баримт бичиг (хүүхдийн төрсний гэрчилгээ, хүүхэд үрчлэн авсан эсвэл асран хамгаалах тухай шүүхийн шийдвэр).
- Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст (Úřad práce) бүртгэлтэй байсан хугацаа, түүнчлэн хамааралтай хүн асран халамжилж байсан гэх мэт бүх цаг үеийн тодорхойлолт гм.
- Тэтгэврийн даатгалын бүртгэлийн хуудас.
- Хэрэв та ажил хийж байгаа бол ажлын тодорхойлолт.
- Хэрэв та тэтгэврээ дансандаа авахыг хүсвэл, банкаар бөглүүлсэн мөн баталгаажуулсан маягт хэрэгтэй.
  - [БНЧУ-ын дансандаа тэтгэвэр авах хүсэлт – данс эзэмшигч](#), эсвэл.
  - [БНЧУ-д данстай эхнэр/нөхрийнхөө дансанд тэтгэвэр авах хүсэлт](#).

**Өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухай шийдвэрийг мөн түүний хэмжээг** Чехийн нийгмийн хамгаалалтын алба өргөдөл гаргаснаас хойш 90 хоногийн дотор гаргадаг. Хариуг таны гарт хүргэнэ. Шийдвэрийн хавсралтад - даатгалын хугацаа, орлогын тойм бүхий хувийн тэтгэврийн даатгалын хуудас багтсан болно. Шийдвэрт тэтгэвэр олгох хугацааг мөн дурдсан байна.

**Тэтгэврийг яаж олгох вэ?** Та тэтгэврийн өргөдөлд аль хэдийн тэтгэвэр олгох аргыг сонгосон байна. Өөрчлөлтийг зөвхөн хүсэлт гаргасны үндсэн дээр өөрчлөх боломжтой. Тэтгэврийг сард нэг удаа олгоно:

- дансанд,
- Чех шуудангаар дамжуулан бэлэн мөнгөөр - 29 кроны хураамж (тэтгэвэр авах бүрд) авна.

**Тэтгэвэр авагч 8 хоногийн дотор дараах зүйлсийг мэдээлэх үүрэгтэй:**

- хаяг солих,
- тэтгэвэр тэтгэмж илгээх дансны дугаарыг өөрчилсөн болон тэтгэвэр олгоход нөлөөлж болзошгүй бусад өөрчлөлтүүдийг.

## АНХААР!

**Та өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ч гэсэн ажил хийж байна уу?** Энэ нь та ажлаасаа гарах шаардлагатай гэсэн үг биш юм. Та нэгэн зэрэг ажиллаж, тэтгэвэр авах боломжтой. Таны орлого ямар нэг байдлаар хязгаарлагдахгүй. Гэхдээ та өвчний тэтгэлэг авах тохиолдолд тэтгэврийн хэмжээнээс үл хамааран дээд тал нь 84 хоног (ажил олгогчоос 14 хоног, OSSZ-аас 70 хоног) нөхөн олгоно гэдгийг анхаарна уу.

**Тодорхой тохиолдлыг харгалзан үзэх шаардлагатай гэдгийг бүү мартаарай!**

Та өндөр насны тэтгэврийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ČSSZ цахим хууднаас авах боломжтой:

<https://www.cssz.cz/web/cz/starobni- duchod>.



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.